



**ХҮНД ДААЦЫН БОЛОН СУУДЛЫН АВТОМАШИНЫ СЭЛБЭГ, ХЭРЭГСЭЛ
ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ**

Дугаар № 69/2022

2022 оны 06-р сарын 10 өдөр

Улаанбаатар хот

Нэг талаас “Амгалан дулааны станц” Төрийн өмчит хувьцаат компани /цаашид “Захиалагч” гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Ш.Баянмөнх нөгөө талаас Пегиколор ХХК-ийг төлөөлж захирал Ц.Мөнгөн-Эрдэнэ /цаашид “Нийлүүлэгч” гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйл, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр Бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дах заалт, 44 дүгээр зүйлийн 44.1 дэх заалт, Монгол Улсын Эрчим хүчний сайдын 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/104 дүгээр тушаал, 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах зүйлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

Нэг. Гэрээгээр нийлүүлэх зүйл, нөхцөл

1.1. Нийлүүлэгч нь “Хүнд даацын болон суудлын автомашины сэлбэг, хэрэгсэл” (цаашид “бараа” гэх)-ыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох хавсралтад заасан ажлыг гүйцэтгэн барааг нэр төрөл, тоо хэмжээ, нэг бүрийн үнэ, техникийн үзүүлэлт, стандартын дагуу Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад нийлүүлнэ.

Хоёр. Бараа нийлүүлэх хугацаа

2.1. Нийлүүлэгч нь барааг гэрээнд хоёр тал гарын үсэг зурж баталгаажуулснаас хойш 45 /дөчин тав/ хоногийн дотор багтаан нийлүүлнэ.

Гурав. Үнэ төлбөрийн нөхцөл

3.1. Энэ гэрээний нийт үнэ 35,471,907 /гучин таван сая дөрвөн зуун далан нэгэн мянга есөн зуун долоо/-н төгрөг бөгөөд үнийн дүнд гааль Онцгой албан татвар, Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад хүргэх тээврийн зардал НӨАТ бүгд шингэсэн байна.

3.2 Гэрээний үнийн дүнгийн 30 /гуч/-н хувь болох 10,641,573 /Арван сая зургаан зуун дөчин нэгэн мянга таван зуун далан гурав/-н төгрөгийг гэрээ баталгаажсанаас хойш ажлын 5 /тав/ хоногийн дотор нийлүүлэгчийн Хаан банкны 5021749743 тоот дансанд шилжүүлнэ. Гэрээний үнийн дүнгийн үлдэгдэл төлбөр 70 /дал/-н хувь болох 24,830,334 /Хорин дөрвөн сая найман зуун гучин мянга гурван зуун гучин дөрөв/-н төгрөгийг бараа хүлээн авсан акт, тайлан, гэрээ дүгнэсэн акт баталгаажсанаас хойш нэхэмжлэлийн дагуу 90/ер/ хоногийн дотор нийлүүлэгчийн Хаан банкны 5021749743 тоот дансанд шилжүүлнэ. Гэрээний явцад үнэ тогтмол байна.

Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага

- 4.1. Нийлүүлэгч нь гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хугацаандаа нийлүүлээгүй барааны нийт үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хоног тутам төлөх ба нийт алдангийн үнийн дүн гэрээний нийт үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.
- 4.2. Захиалагч нь барааны бүрэн бүтэн байдал, техникийн үзүүлэлт, шаардлагад тохирч байгаа эсэхийг шалган үзээд хүлээн авсаны дараа гэрээнд заасан хугацаанд тооцоо хийх, төлбөрийн хугацааг хожимдуулбал хожимдсон хоног тутамд хүлээгдэж байгаа төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг Нийлүүлэгчид төлөх ба алдангийн дүн нь гэрээний төлбөрийн үнийн дүнгийн 10% хувиас хэтрэхгүй байна.
- 4.3. Барааг Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад ирсэний дараа тус компанийн бараа хүлээн авах комисс шаардлага хангаж байгааг тогтоосон тохиолдолд барааг хүлээн авна. Барааг шаардлага хангаагүй тохиолдолд буцаана.
- 4.4. Захиалагчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг Амгалан дулааны станц ТӨХК-ийн АХММХМ инженер Н.Сайнбилэг хариуцан ажиллана. Утас-98109919.
- 4.5. Нийлүүлэгчийг төлөөлж гэрээтэй холбоотой асуудлыг Пегиколор ХХК-ийн захирал Ц.Мөнгөн-Эрдэнэ хариуцан ажиллана. Утас- 99045264.

Тав. Бараа бүтээгдэхүүний чанар, сав, баглаа, боодол

- 5.1. Нийлүүлэгчийн нийлүүлэх бараа нь Олон улсын болон Монгол улсын стандарт шаардлагыг бүрэн хангасан байна.
- 5.2. Бараа нь тээвэрлэлт, хадгалалтын үед гэмтэхээс хамгаалсан сав, баглаа боодолтой байна.
- 5.3. Барааг захиалагчид хүлээлгэн өгөх үед энэхүү гэрээгээр тодорхойлсон чанар стандартад нийцэж байвал зохих бөгөөд цаашид технологийн горим, зориулалтын дагуу ашиглах хугацаанд чанараа алдахгүй байх ёстой.
- 5.4. Нийлүүлсэн бараанд ямар нэгэн дутагдал, шаардлагад нийцээгүй бараа илэрвэл дутагдлыг арилган, сольж өгөхийг Захиалагч шаардах ба нийлүүлэгч шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.
- 5.5. Нийлүүлэгч нь нийлүүлсэн барааг ашиглаж эхэлсэн өдрөөс хойш 6 /зургаа/-н сарын баталгаа гаргана. Баталгаат хугацаанд нийлүүлэгчийн үйл ажиллагаатай холбогдон гарсан гэмтэл, доголдлыг өөрийн зардлаар засаж залруулах үүрэгтэй.

Зургаа. Бараа хүлээн авах

- 6.1. Нийлүүлэгчийн ачигдсан барааг Улаанбаатар хотын Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад бараа хүлээн авах комисс хүлээн авна.
- 6.2. Нийлүүлэгч нь барааг Захиалагчид хүлээлгэн өгөх хүртэлх бүх зардлыг хариуцна.

Долоо. Давагдашгүй хүчин зүйл

- 7.1. Гэрээг хэрэгжүүлэх явцад улс төрийн хориг, байгалийн гамшиг, хорио цээр тогтоох, цэргийн үймээн, төрийн эргэлт, ажил хаялт болон бусад нөхцлүүд бий болсноос үүдэж гэрээний нөхцлүүд хэсэгчлэн болон бүрэн биелээгүй тохиолдолд хоёр талын аль нь ч хариуцлага хүлээхгүй.
- 7.2. Давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлүүд гарч эхэлсэн тохиолдолд 10 хоногийн дотор талууд бие биедээ бичгээр мэдээлж цаашид хэрхэн ажиллах талаар зөвшилцөнө.

Найм. Гэрээг цуцлах үндэслэл

- 8.1. Нийлүүлэгч нь бараа материал нийлүүлэх энэхүү гэрээнд зааснаас 30 хоног хэтрүүлсэн тохиолдолд Захиалагч гэрээг цуцлах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид албан ёсоор бичгээр өгнө. Нийлүүлэгч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 5

хоногийн дотор зохих хариуг өгч тодорхой арга хэмжээ аваагүй тохиолдолд захиалагч гэрээг цуцлана.


8.2. Нийлүүлэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа буюу ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд Захиалагч энэхүү гэрээний үйлчлэлийг дуусахаас өмнө тасалдуулахгүй.


Ес. Бусад нөхцөл

- 9.1. Талуудын аль нэг нь нөгөөдөө гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 10 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.
- 9.2. Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 9.3. Гэрээг монгол хэл дээр 4 хувь үйлдэж, Захиалагч 3 хувийг Нийлүүлэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 9.4. Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд сунгаж болно.
- 9.5. Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болно.
- 9.6. Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмж засварласан эх хувьд баллаж засварласан буюу гараар нэмж бичсэн болон бусад энгийн аргаар хийсэн оруулга засвар нэмэлт бичилтийг хүчинтэйд тооцохгүй.
- 9.7. Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.


ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН
СЭЗХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ
НЯГТЛАН БОДОГЧ
Ө.УДВАЛ
Гарын үсэг: 

ХАНГАМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Г.ЭРДЭНЭБИЛЭГ
Гарын үсэг: 


АХММХМ ИНЖЕНЕР
Н.САЙНБИЛЭГ
Гарын үсэг: 

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН
Г.САРУУЛ
Гарын үсэг: 

ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН:
ХАНГАМЖИЙН МЭРГЭЖИЛТЭН
Ш.ГАНГУЛГА
Гарын үсэг: 

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1
Утасны дугаар: 77111251
РД: 6021646

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ПЕГИКОЛОП
ХХК-ИЙН ЗАХИРАЛ
Ц.МӨНГӨН-ЭРДЭНЭ
Гарын үсэг: 



Хаяг: УБ хот СХД 19-р хороо 21-р хороолол
Цахилгаан тээвэр хашаа-1 тоот
Утас: 99045264
РД: 5497205

Барааны үнийн хуваарь

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|----|-----------------------------------|-------------------|------------|------------------|----------------|---------------------------------|--|--|-----------------------------------|
| № | Барааны нэр | Гарал үүслийн улс | Тоо хэмжээ | Хэмжих нэгж, тун | Нэгж үнэ | Нэр төрөл бүрийн бүгд үнэ (4x6) | Дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ | Бараа нийлүүлэхэд ногдох татвар, хураамж | Нэр төрөл бүрийн нийт үнэ (7+8+9) |
| 1 | Агаар шүүгч | БНХАУ | 2 | ш | ₮ 96,000.00 | ₮ 192,000.00 | ₮ 7,680 | ₮ 19,968 | ₮ 219,648 |
| 2 | Хропны засвар /Ражектор/ | БНХАУ | 1 | ш | ₮ 1,440,000.00 | ₮ 1,440,000.00 | ₮ 57,600 | ₮ 149,760 | ₮ 1,647,360 |
| 3 | Аккумулятор | БНХАУ | 2 | ш | ₮ 672,000.00 | ₮ 1,344,000.00 | ₮ 53,760 | ₮ 139,776 | ₮ 1,537,536 |
| 4 | Редуктор паб /Урд, хойд/ | БНХАУ | 4 | ш | ₮ 168,000.00 | ₮ 672,000.00 | ₮ 26,880 | ₮ 69,888 | ₮ 768,768 |
| 5 | Нэмэлт паар | БНХАУ | 1 | ш | ₮ 192,000.00 | ₮ 192,000.00 | ₮ 7,680 | ₮ 19,968 | ₮ 219,648 |
| 6 | Ээлж хийх /Мотор/ | БНХАУ | 1 | ком | ₮ 8,304,000.00 | ₮ 8,304,000.00 | ₮ 332,160 | ₮ 863,616 | ₮ 9,499,776 |
| 7 | Тоормозны дээд аппарат | БНХАУ | 2 | ш | ₮ 115,200.00 | ₮ 230,400.00 | ₮ 9,216 | ₮ 23,962 | ₮ 263,578 |
| 8 | Пирда диск | БНХАУ | 1 | ш | ₮ 672,000.00 | ₮ 672,000.00 | ₮ 26,880 | ₮ 69,888 | ₮ 768,768 |
| 9 | Наклад/хово | БНХАУ | 1 | ш | ₮ 220,800.00 | ₮ 220,800.00 | ₮ 8,832 | ₮ 22,963 | ₮ 252,595 |
| 10 | Цапны босоо пальц | БНХАУ | 1 | ком | ₮ 288,000.00 | ₮ 288,000.00 | ₮ 11,520 | ₮ 29,952 | ₮ 329,472 |
| 11 | Кабины амортизатор/хово | БНХАУ | 4 | ш | ₮ 172,800.00 | ₮ 691,200.00 | ₮ 27,648 | ₮ 71,885 | ₮ 790,733 |
| 12 | Хийн амортизатор | БНХАУ | 2 | ш | ₮ 240,000.00 | ₮ 480,000.00 | ₮ 19,200 | ₮ 49,920 | ₮ 549,120 |
| 13 | Турбо | БНХАУ | 1 | ш | ₮ 1,296,000.00 | ₮ 1,296,000.00 | ₮ 51,840 | ₮ 134,784 | ₮ 1,482,624 |
| 14 | Духны ремен | БНХАУ | 1 | ш | ₮ 172,800.00 | ₮ 172,800.00 | ₮ 6,912 | ₮ 17,971 | ₮ 197,683 |
| 15 | Хийн амортизатор | БНХАУ | 2 | ш | ₮ 206,400.00 | ₮ 412,800.00 | ₮ 16,512 | ₮ 42,931 | ₮ 472,243 |
| 16 | Үндсэн амортизатор | БНХАУ | 4 | ш | ₮ 163,200.00 | ₮ 652,800.00 | ₮ 26,112 | ₮ 67,891 | ₮ 746,803 |
| 17 | Нумны срочик | БНХАУ | 2 | ш | ₮ 312,000.00 | ₮ 624,000.00 | ₮ 24,960 | ₮ 64,896 | ₮ 713,856 |
| 18 | Урд зөв талын 2,5,6-р өнгө | БНХАУ | 1 | ком | ₮ 480,000.00 | ₮ 480,000.00 | ₮ 19,200 | ₮ 49,920 | ₮ 549,120 |
| 19 | Барбан | БНХАУ | 1 | ш | ₮ 336,000.00 | ₮ 336,000.00 | ₮ 13,440 | ₮ 34,944 | ₮ 384,384 |
| 20 | Наклад | БНХАУ | 8 | ш | ₮ 139,200.00 | ₮ 1,113,600.00 | ₮ 44,544 | ₮ 115,814 | ₮ 1,273,958 |
| 21 | Харандаа голын сальник | БНХАУ | 1 | ш | ₮ 96,000.00 | ₮ 96,000.00 | ₮ 3,840 | ₮ 9,984 | ₮ 109,824 |
| 22 | Захын дамжуулахын сальник | БНХАУ | 4 | ш | ₮ 172,800.00 | ₮ 691,200.00 | ₮ 27,648 | ₮ 71,885 | ₮ 790,733 |
| 23 | Урд тормозны аппарат /Дээд, Доод/ | БНХАУ | 1 | ком | ₮ 172,800.00 | ₮ 172,800.00 | ₮ 6,912 | ₮ 17,971 | ₮ 197,683 |
| 24 | Автомат | БНХАУ | 1 | ш | ₮ 1,104,000.00 | ₮ 1,104,000.00 | ₮ 44,160 | ₮ 114,816 | ₮ 1,262,976 |
| 25 | Будаатай шүүр | БНХАУ | 3 | ш | ₮ 105,600.00 | ₮ 316,800.00 | ₮ 12,672 | ₮ 32,947 | ₮ 362,419 |
| 26 | Хаалганы толь /4743/ | БНХАУ | 1 | ш | ₮ 70,848.00 | ₮ 70,848.00 | ₮ 2,900 | ₮ 7,375 | ₮ 81,123 |
| 27 | Нумны гулгаа | БНХАУ | 2 | ш | ₮ 288,000.00 | ₮ 576,000.00 | ₮ 23,040 | ₮ 59,904 | ₮ 658,944 |
| 28 | Туслах хропны сальник /4743/ | БНХАУ | 1 | ш | ₮ 312,000.00 | ₮ 312,000.00 | ₮ 12,480 | ₮ 32,448 | ₮ 356,928 |
| 29 | Бембран | БНХАУ | 4 | ш | ₮ 124,800.00 | ₮ 499,200.00 | ₮ 19,968 | ₮ 51,917 | ₮ 571,085 |
| 30 | Луклорон | БНХАУ | 4 | ш | ₮ 76,800.00 | ₮ 307,200.00 | ₮ 12,288 | ₮ 31,949 | ₮ 351,437 |

| | | | | | | | | | | | | | | |
|----|--------------------------|-------|----|-----|---|--------------|---|--------------|---|---------|--------------------------|---------|---------------------|-----------|
| 31 | Дугуйн шелик | ХАУ | 20 | ш | ₮ | 9,600.00 | ₮ | 12,000.00 | ₮ | 7,680 | ₮ | 19,968 | ₮ | 219,648 |
| 32 | Халуун тогоо /5653/ | БНХАУ | 1 | ш | ₮ | 960,000.00 | ₮ | 960,000.00 | ₮ | 38,400 | ₮ | 99,840 | ₮ | 1,098,240 |
| 33 | Босоо, Хэвтээ тэнцүүлэгч | БНХАУ | 2 | ш | ₮ | 460,800.00 | ₮ | 921,600.00 | ₮ | 36,864 | ₮ | 95,846 | ₮ | 1,054,310 |
| 34 | Моторын ээлж | БНХАУ | 1 | ком | ₮ | 3,840,000.00 | ₮ | 3,840,000.00 | ₮ | 153,600 | ₮ | 399,360 | ₮ | 4,392,960 |
| 35 | Үнс буулгах хаалт | БНХАУ | 4 | ш | ₮ | 115,200.00 | ₮ | 460,800.00 | ₮ | 18,432 | ₮ | 47,923 | ₮ | 527,155 |
| 36 | Үнс буулгах шланк | БНХАУ | 2 | ш | ₮ | 336,000.00 | ₮ | 672,000.00 | ₮ | 26,880 | ₮ | 69,888 | ₮ | 768,768 |
| | | | | | | | | | | | НӨАТ-тай нийт үнэ | | ₮ 35,471,907 | |

Амгалан дулааны станц ТӨХК-ийн
АХММХМ инженер



Н.Сайнбилэг

Пегиколор ХХК-ийн
Захирал

